



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2008 оны 4 сарын 03 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалт, "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 40.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 27 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Ард" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2002 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс тасалбар болгон татан буулгаж, тус үйлдвэрийн газрын захирал Б.Нинжбадгарыг мөн өдрөөр тооцож үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. "Ард" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах комиссыг хавсралтаар баталсугай.

Гурав. Тус газар татан буугдсантай холбогдуулан ажилтан, албан хаагчдад Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу зохих тэтгэмж олгохыг "Ард" нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /Б.Нинжбадгар/, татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

Дөрөв. Байгууллагын хаалтын балансыг 2002 оны 6 дугаар сарын 1-ний дотор гаргаж, архивын бичиг баримтуудын хамт холбогдох байгууллагуудад шилжүүлэхийг "Ард" нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /Б.Нинжбадгар/, татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

Тав. "Ард" кино компаний авлага, өр төлбөрийг байгууллага хүмүүстэй тооцоо нийлсэн дүнгээр барагдуулж, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/, татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/-т үүрэг болгосугай.

Зургаа. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Ард" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын урьд мөрдөж байсан дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

02 0410



Нийслэлийн Засаг даргын 2002 оны
148-р тоот захирамжийн хавсралт

"Ард" нийслэлийн өмчит үйлдвэрийн
газрыг татан буулгах комисс

Комиссын дарга	Ж.Эрдэнэбаатар	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын хэлтсийн дарга
Гишүүдэд	Б.Бүрэнцэцэг	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын мэргэжилтэн
	Г.Гансүрэн	- Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын мэргэжилтэн
	Ш.Сэргэлэн	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	С.Жимээхүү	- Нийслэлийн Соёлын газрын мэргэжилтэн